



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 25

Урт

┌ Хуралдаан зарлан хуралдуулах тухай ┐

Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын долоо дахь удаагийн сонгуулийн ээлжит 4 дүгээр хуралдааныг 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 09 цагаас зарлан хуралдуулж дараах асуудлыг хэлэлцэхээр баталсугай. Үүнд:

- 1.1. Тэргүүлэгч нөхөн сонгох тухай
- 1.2. Сумын 2017 оны төсвийн тодотгол батлах тухай
- 1.3. Сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- 1.4. Орон нутгийн тусгай хэрэгцээнд газар авах, чөлөөлөх тухай

2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит 4 дүгээр хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд танилцуулахыг Хурлын дарга /Б.Отгонбаяр /-д даалгасугай.

3. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 4 дүгээр хуралдааны бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба /П.Одончимэг/, Засаг даргын Тамгын газар /Ц.Дэлгэрмаа/-т үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 26

Урт

┌ Журам батлах тухай ─┐

Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Гурвантэс сумаас Их дээд сургуульд сурч буй оюутныг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах журмыг нэгдүгээр, Оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг хариуцан зохион байгуулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 26 дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт



**ГУРВАНТЭС СУМААС ИХ ДЭЭД СУРГУУЛЬД СУРЧ БУЙ
ОЮУТНЫГ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРТ
ХАМРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.6-д заасны дагуу Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагын бакалавр, магистрын боловсрол эзэмших өдрийн, эчнээ ангид сурч байгаа иргэнд тус тус сургалтын төлбөр, суралцагчийн тэтгэлэг, санхүүгийн дэмжлэгийг (цаашид "тэтгэлэг" гэх) олгоход энэхүү журмыг дагаж мөрдөнө.
- 1.2. "Оюутны тэтгэлэгт хөтөлбөр"-ийг удирдан зохион байгуулагч нь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллага, иргэний төлөөлөл бүхий 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хариуцан гүйцэтгэнэ.
- 1.3. Тухайн ажлын хэсэг нь энэхүү журмыг мөрдөн ажиллана.
- 1.4. Гурвантэс суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, Аж ахуйн нэгж, уул уурхайн компани нь (цаашид "хөтөлбөрийг санхүүжүүлэгч" гэх) идэвхитэй оролцоно.
- 1.5. "Хөтөлбөрийг санхүүжүүлэгч" нь тухайн ажлын хэсгийн шийдвэрийг үндэслэн тэтгэлэг горилогчид тэтгэлэг олгоно.
- 1.6. "Оюутны тэтгэлэгт хөтөлбөр"-т хамрагдах оюутан, залуучуудыг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Энэхүү хөтөлбөрийн зорилго

- 2.1. Гурвантэс сумын мэргэжилтэй боловсон хүчний нөөцийн бодлого, нийгэм, эдийн засгийн салбарт шаардлагатай мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэхэд анхаарч санхүүгийн дэмжлэг үзүүлэн орон нутагт ирж ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Дараах мэргэжлээр суралцаж байгаа оюутан, залуучуудыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна:

1. Соёл урлагийн салбар / дуу хөгжим, бүжгийн багш, түүх дурсгал музейн мэргэжилтэн/
2. ХАА-н салбар/ малын их эмч, мал зүйч, фермерийн мэргэжилтэн, бэлчээрийн мэргэжилтэн, агрономич/
3. Байгаль орчны салбар /нөхөн сэргээлтийн инженер, биотехнологич, хөрс судлаач/
4. Усан хангамжийн инженер
5. Төмөр зам болон авто замын инженер, техникийн ажилтан, мэргэжилтэн
6. Хөнгөн үйлдвэрийн чиглэлийн мэргэжилтэн, хүнсний технологич, биохимич
7. Эмнэлэгийн нарийн мэргэжлийн эмч, Их эмч

8. Багш /математик, хими, физик, биологи, гадаад хэл, дуу хөгжим, цэцэрлэг, бага ангийн багш /
9. Өндөр технологи, био, нано, мэдээллийн технологийн чиглэлийн мэргэжилтэн
10. Уул уурхайн тоног төхөөрөмж, машин механизмын инженер, техникийн ажилтан
11. Цаг уурын мэргэжилтэн

Дөрөв. Тэтгэлэгт хамрагдах оюутан, сурагчдад тавигдах шаардлага:

1. Анхлан суралцагчид

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн 12-р ангийг төгссөн байх
- Гурвантэс сумын оршин суугч байх
- МУ-н магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд суралцагч
- БСШУЯ-наас магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагад зохих журмын дагуу элссэнийг нотлох боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын эрхийн бичигтэй
- Сургуулиа төгсөөд орон нутагтаа ирж ажиллах хүсэлтэй
- Тус суманд шаардлагатай мэргэжлээр суралцдаг байх
- Бүрэн дунд боловсролын гэрчилгээний голч дүн 85%-иас доошгүй байх
- Өмнө нь гэр бүлийн бусад гишүүдээс сургалтын тэтгэлэгт хамрагдаагүй байх

2. Одоо суралцаж буй оюутан

- Гурвантэс сумын оршин суугч
- БСШУЯ-наас магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд суралцаж байгаа
- Сургуулиа төгсөөд орон нутагтаа ирж ажиллах хүсэлтэй
- Тус суманд шаардлагатай мэргэжлээр суралцдаг байх
- Сурлагын голч дүн нь 3.0 ба түүнээс дээш
- Төрийн болон хувийн байгууллагаас зарлагдсан бусад тэтгэлэгт хамрагдаагүй байх
- Өмнө нь гэр бүлийн бусад гишүүдээс сургалтын тэтгэлэгт хамрагдаагүй байх

Тав. Бүрдүүлэх материал:

1. Анхлан суралцагчид

- Анкет
- Бүрэн дунд боловсролын гэрчилгээний хуулбар
- Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын эрхийн бичиг, нотариатаар батлуулсан хуулбар
- Оршин суугаа газрын тодорхойлолт
- Иргэний үнэмлэх, хуулбарын хамт
- ЗХ4 хэмжээтэй цээж зураг 2%
- Гар өргөдөл

- Эссэ /500 үгтэй /
- Сурч байх хугацаандаа оюуны болон урлаг, спортын уралдаан тэмцээнд орж амжилт, гаргаж байсан бол давуу тал болно. /Хэрэв тийм бол фото зураг, гэрчилгээ зэргийг авч ирэх/

2. Одоо суралцаж буй оюутан

- Анкет
- Сургуулийн сургалтын албанаас баталгаажсан голч дүнгийн тодорхойлолт
- Оршин суугаа газрын тодорхойлолт
- Дүнгийн дэвтэр, нотариатаар батлуулсан хуулбар
- Иргэний үнэмлэх, хуулбарын хамт
- ЗХ4 хэмжээтэй цээж зураг 2%
- Сурч байх хугацаандаа оюуны болон урлаг, спортын уралдаан тэмцээнд орж амжилт, гаргаж байсан бол давуу талтай. /Хэрэв тийм бол фото зураг, гэрчилгээ зэргийг авч ирэх/
- Гар өргөдөл
- Эссэ / 500 үгтэй/

Зургаа. Материал хүлээн авах хаяг, хугацаа:

Тэтгэлэг горилогчийн материалыг дараах хаягаар хүлээн авна.

- Гурвантэс сумын Засаг даргын тамгын газрын Дотоод ажил нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэнд бүртгүүлэх, эсвэл Засаг даргын тамгын газрын албан ёсны цахим хаягаар хүлээн авна.

Материал хүлээн авах хугацаа:

- Жил бүрийн 07 сарын 20-с 09 сарын 20 хүртэл материалыг хүлээж авна

Долоо. Сонгон шалгаруулалтыг зарлаж мэдээлэх тухай

Сонгон шалгаруулалтыг сумын Засаг даргын Тамгын газар болон 1 сарын өмнө нийтэд зарлаж мэдэгдэнэ. Мөн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудсуудаар зарлан мэдээлнэ.

Найм. Сонгон шалгаруулах үйл ажиллагаа:

“Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг ажлын хэсэг нь бүртгэлийг тогтоосон хугацаанд явуулж дараах байдлаар сонгон шалгаруулна. Үүнд:

1. Бичиг баримтын бүрдүүлэлтэнд хяналт хийх:

- Ирүүлсэн материалын иж бүрдэл, голч дүн, хаяг, байршлын судалгаа гаргах, шаардлагатай тохиолдолд улсын бүртгэлийн хэлтсээс лавлагаа

авах, оюун ухаан, мэдлэг чадвар, авъяас билэг, хүч чадлаараа байгуулсан амжилт, бүтээлтэй танилцах.

- Өмнө нь гэр бүлийн гишүүдээс хэн нэг нь сургалтын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж байсан эсэх судалгааг гаргах
- Гэр бүлийн гишүүний хэн нэгэн зорилтод бүлэгт хамрагддаг эсвэл 2 ба түүнээс дээш оюутантай зэрэг шалтгааныг харгалзан үзнэ.

Энэ шалгалтад тэнцээгүй иргэдэд шууд мэдэгдэж материалыг буцааж өгнө.

2. Ярилцлага:


- Бичиг баримтын сонгон шалгаруулалтанд тэнцсэн хүн ярилцлаганд орно. Ярилцлагыг уг хүний мэдлэг, боловсрол, дадал зуршил, сэтгэлгээ, өөрийгөө илэрхийлэх чадвар, хүсэл мөрөөдөл, бусдаас ялгарах давуу тал, цаашид суралцах хүсэл эрмэлзэл, амьжиргааны түвшин зэргийг нь таньж мэдэх зорилгоор харилцан ярилцах журмаар явуулна.

Ес. Суралцагчдыг “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-т хамруулах

- Сонгон шалгаруулалтанд тэнцсэн оюутны материалыг санхүүжүүлэгч байгууллагад хүргүүлэх
- Сумын Засаг дарга, Санхүүжүүлэгч байгууллага, Оюутаны 3 талт гэрээ байгуулах

---- о О о ---

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 26 дугаар тогтоолын
хоёрдугаар хавсралт



ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙГ

ХАРИУЦАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. О.Баттогтох /сумын Засаг дарга/
2. М.Мөнхбархас /Засаг даргын тамгын газрын Дотоод ажил, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн/
3. Н.Цэрэннадмид /Засаг даргын тамгын газрын Хөдөлмөр, нийгмийн халамж үйлчилгээний мэргэжилтэн /
4. Б.Тогтохмаа /"Саус гоби сэндс" ХХК-ны төлөөлөгч/
5. С.Шинэсар /Оюутны төлөөлөл/